



**“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.9 дэх заалт, Компанийн
дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дах заалтуудыг тус тус удирдлага болгон “Мандал Даатгал”
ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус
тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн
дээр 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын
комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт
№1-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ



**“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10 дах заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Мандал Даатгал” ХК-ийн 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай:

- а. Ноён О.Ганжолоо (ердийн гишүүн)
б. Ноён Н.Мэндбаяр (ердийн гишүүн)

2. “Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд Хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бусад гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл хугацаагаар сонгосугай.

3. сонгосугай:

- а. Ноён Спенс Роберт Хектор Жон (ердийн гишүүн)
б. Ноён Томас Патрик Холланд (ердийн гишүүн)

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ



**“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны
зардлын төсөв батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дах заалтуудыг тус тус удирдлага болгон “Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай.

№	Зардлын төсөв	Нийт зардал (төгрөг)
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал	189,600,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	36,000,000
Дүн		245,600,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ